



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2025 оны 10 сарын 29 өдөр

Дугаар A-246

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Монголбанкны Мөнгөний Бодлогын Хорооны ажиллах журам"-ыг хавсралтын дагуу шинэчлэн баталж, батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А-143 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Дотоод аудитын газар (А.Шижирмаа)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

1525012008



МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 273 дугаар зүйлд заасан Мөнгөний бодлогын хороо(цаашид “Хороо” гэнэ)-ны үйл ажиллагаа, зарчим, хуралдааны дэг, хурлаас гарах шийдвэр, түүнийг олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хорооны үйл ажиллагаа нь мөнгөний болон макро зохистой бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааны бие даасан, нээлттэй, хариуцлагатай байдлыг хангах, олон нийтийн Төв банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

1.3. Хорооны үйл ажиллагаандаа хамтын шийдвэр гаргах, мэргэжлийн байх, хариуцлагатай байх, хараат бус байх зарчмыг баримталана.

1.4. Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27³ дугаар зүйлд заасны дагуу хорооны үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан (цаашид “Хуралдаан” гэх) байна.

1.5. Хорооноос гаргах шийдвэрийг албажуулахдаа тогтоосон загвараар үйлдсэн хэвлэмэл хуудас ашиглана.

ХОЁР.ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Хороо нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 27³ дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 7 гишүүнээс бүрдэх бөгөөд гишүүд хэлэлцэх асуудлаар тэнцүү саналын эрхтэй байна.

2.2. Хорооны үйл ажиллагааны хэлбэр нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 27³ дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу ээлжит болон ээлжит бус хуралдаан байна.

2.3. Хуралдааны товыг тухайн жилийн нэгдүгээр сард багтааж Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлан олон нийтэд зарлана.

2.4. Батлагдсан хурлын товд тогтоосон хугацаанаас ажлын 3 өдрийн өмнө өөрчлөлт оруулж болох бөгөөд өөрчлөгдсөн товыг гишүүдэд ажлын 3 өдрийн дотор багтаан мэдэгдэнэ.

2.5. Хорооны хуралдаан болохоос ажлын 5 өдрийн өмнө хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичгийг хорооны гишүүдэд бичгээр эсвэл цахим шуудангаар хүргүүлнэ.

2.6.Ээлжит бус хуралдаан хуралдуулах санал нь эдийн засгийн нөхцөл байдал, зохицуулалтын орчин, санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлөхүйц хүчин зүйлийн улмаас шийдвэр гаргах шаардлагыг илэрхийлсэн агуулгатай байна.

2.7.Хуралдаанд дөрвөөс доошгүй гишүүд оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно.

2.8.Хорооны гишүүн (цаашид “Гишүүн” гэх) хуралдаанд биечлэн оролцоно. Гишүүн хуралдааны хэлэлцэх асуудлаар өөрийн саналыг урьдчилж өгөхийг хориглоно.

2.9.Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасны дагуу Монголбанкны Ерөнхийлөгч хуралдааныг даргалах бөгөөд түүний эзгүйд хуульд заасан этгээд даргална.

2.10.Гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй бол хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэнэ.

2.12.Хороо нь хуралдааны тов батлуулах, түүнийг мэдэгдэх, хуралдааны бэлтгэл хангах, хуралдааны журам, дэгийг баримтлах, хорооны шийдвэрийг албажуулах, мөрдөхөөс өмнө хүргүүлэх чиг үүрэгтэй Нарийн бичгийн даргатай байна. Нарийн бичгийн даргыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар томилно.

ГУРАВ. ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭГ

3.1.Хорооны хуралдаанаар хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэнэ:

3.1.1.Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27³ дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1 дэх заалтын дагуу Төрийн мөнгөний бодлогын төслийг хэлэлцэж шийдвэрлэхдээ мөнгөний бодлогын зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төслийг хэлэлцэнэ.

3.1.2.Мөнгөний бодлогын үндсэн зорилт болох хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх үнийн тогтвортой байдлыг хангах хүрээнд Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27³ дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 2 дахь заалтын дагуу мөнгөний бодлогын хэрэгслийн хүүг тогтоох, өөрчлөх эсэхийг хэлэлцэж шийдвэрлэнэ.

3.1.3.Санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, эрсдэл хуримтагдааас сэргийлэх зорилгоор Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27³ дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалтын дагуу банкны заавал байлгах нөөц, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулах эсэхийг хэлэлцэж шийдвэрлэнэ.

3.2.Хуралдаан нь “Эхний хэлэлцүүлэг” болон “Шийдвэр гаргах” гэсэн хоёр үе шаттай байна.

3.3.Хороо нь энэ журмын 3.1.1-д заасан асуудлыг зөвхөн эхний хэлэлцүүлгийн шатаар, 3.1.3-д заасан асуудлыг зөвхөн шийдвэр гаргах шатаар хэлэлцэнэ.

3.4.Эхний хэлэлцүүлгийн шатанд гадаад, дотоод эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын төлөв, бодлогын саналд тусгагдах бусад шинжилгээний үр дүн болон эдийн

засагт үүсч болзошгүй гол эрсдэл болон бусад асуудлын талаар Мөнгөний бодлого хариуцсан газар, нэгж танилцуулна.

3.5.Эхний хэлэлцүүлгийн шатанд бодлогын шийдвэр гаргахад мэдээлэл болох нэмэлт тооцоолол, шинжилгээ болон судалгааны үр дүнг холбогдох бусад газар, нэгж танилцуулж болно.

3.6.Хорооны гишүүн эхэлж эхний хэлэлцүүлэг дээр хэлэлцсэн асуудлын хүрээнд тодруулах, асуулт асуух бөгөөд дараа нь өөрийн байр сууриа илэрхийлэх, санал гаргаж болно.

3.7.Хорооны хуралдаанд хэлэлцүүлэх асуудлыг газар, нэгжийн захирал биечлэн танилцуулах бөгөөд газар, нэгжийн захирал хүндэтгэх шалтгаанаар эзгүй болон 2-оос дээш танилцуулга хийх тохиолдолд тухайн газрын холбогдох хэлтсийн захирал танилцуулж болно.

3.8.Танилцуулга хийх газар, албаны холбогдох ажилтнууд болон мөнгөний бодлогын чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтэн, судлаачид эхний хэлэлцүүлэгт оролцож, судалгааны үр дүн, өөрсдийн санал бодлоо илэрхийлэх, гишүүдийн асуултад хариулт өгч болно.

3.9.Эхний хэлэлцүүлгийн явцад эдийн засгийн өнөөгийн болон цаашдын төлөвийн талаарх мэдээлэлд нэмэлт тооцоолол, шинэ мэдээлэл оруулах шаардлагатай гэж Хорооны дөрвөөс доошгүй гишүүн үзсэн тохиолдолд Хорооны даргын зөвшөөрснөөр эхний хэлэлцүүлгийг дараагийн ажлын 5 өдөрт багтаан дахин хуралдуулахаар завсарлаж болно.

3.10.Эхний хэлэлцүүлгийн хуралдаанаас хойш ажлын 3 өдрийн дотор шийдвэр гаргах хуралдаан болно.

3.11.Шийдвэр гаргах шатанд мөнгөний бодлогын санал, түүний үндэслэл болон бодлогын хувилбаруудыг Мөнгөний бодлого хариуцсан газраас танилцуулна.

3.12.Шийдвэр гаргах шатанд эдийн засгийн гэнэтийн шокийн санхүүгийн салбар, тэр дундаа банкны салбарт үзүүлэх нөлөөний симуляц шинжилгээний үр дүнг танилцуулна. Энэ нь бодлогын хэрэгслүүдийн өөрчлөлтийн нөлөөг тооцоолсон симуляц шинжилгээг агуулна. Уг шинжилгээ, дүгнэлтэд үндэслэн макро зохистой бодлогын санал, түүний үндэслэл болон хувилбаруудын саналыг Макро зохистой бодлого хариуцсан нэгж танилцуулна.

3.13.Хорооны гишүүн бүр эхэлж хэлэлцэж буй бодлогын саналын талаар тодруулга, асуулт тавих бөгөөд дараа нь бодлогын саналыг дэмжих эсхүл эсэргүүцэх чиглэлээр өөрийн байр сууриа холбогдох үндэслэлийн хамт илэрхийлж, танилцуулна.

3.14.Шийдвэр гаргах шатанд Монголбанкны Ерөнхий эдийн засагч, Мөнгөний болон Макро зохистой бодлого хариуцсан газар, нэгжийн захирлууд болон бусад холбогдох газрын захирал саналын эрхгүйгээр оролцож, гишүүдийн асуултад хариулах, өөрсдийн хариуцсан чиглэлээр санал, дүгнэлтээ илэрхийлж болно.

3.15.Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлаар гишүүн ил санал хураалтаар гар өргөн саналаа өгч, олонхийн саналаар шийдвэрлэнэ.

3.16.Санал хураалт явуулах үед гишүүн санал өгөх эрхээ зөвхөн өөрөө эдлэх бөгөөд энэхүү эрхээ бусдад шилжүүлэх, бусдын өмнөөс санал өгөхийг хориглоно.

3.17.Бодлогын шийдвэр гарсаны дараа Мөнгөний болон Макро зохистой бодлогын мэдэгдлийн төслийг хэлэлцэн баталж, шийдвэрийг олон нийтэд хүргэх чиглэл, арга хэлбэрийн талаар Монголбанкны баримтлах нэгдсэн байр суурийг тодорхойлно.

3.18.Гишүүн шийдвэр гаргах асуудлаар өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хувьд ашиг сонирхолын зөрчил үүсч болзошгүй, зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалтай гэж үзвэл санал хураалтад оролцохоос сайн дураараа татгалзах бөгөөд энэ тухайгаа хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэнэ.

3.19.Хуралдаан дээр Хорооны нарийн бичгийн даргаас бусад этгээд аливаа хэлбэрээр дуу, дүрс бичлэг хийж, хадгалахыг хориглоно.

3.20.Зайлшгүй шаардлагатай, эсхүл хууль тогтоомжид тусгайлан заасан тохиолдолд Хорооны даргын шийдвэрээр хуралдааныг хаалттай хэлбэрээр явуулж болно.

ДӨРӨВ. ХОРООНЫ ШИЙДВЭРИЙГ МЭДЭЭЛЭХ

4.1.Хорооны хуралдаанаас гарах тогтоолын төслийг Мөнгөний бодлого болон Макро зохистой бодлого хариуцсан газар урьдчилан боловсруулж, холбогдох газар, нэгжээс санал авч бэлтгэнэ.

4.2.Мөнгөний бодлогын хорооны тогтоолын хуулбарыг баталгаажуулснаас хойш ажлын 1 өдрийн дотор Нарийн бичгийн дарга Монголбанкны Албан хэрэг хөтлөлтийн электрон системээр холбогдох газарт хүргүүлнэ.

4.3.Мөнгөний бодлогын мэдэгдлийн төслийг Мөнгөний болон Макро зохистой бодлого хариуцсан нэгж дараах бүтцээр боловсруулах бөгөөд хэмжээ нь 1.5 нүүрнээс хэтрэхгүй байна. Үүнд:

4.3.1.Шийдвэр хэрэгжиж эхлэх огноо; хуралдааны шийдвэр;

4.3.2.Инфляци, эдийн засгийн өсөлтийн ойрын ирээдүйн төлөвийг өмнөх хуралдаанаас хойш эдийн засагт гарсан гол өөрчлөлттэй уялдуулан товч тайлбарлах;

4.3.3.Шийдвэрийн үндэслэл, түүний хүлээгдэж буй үр дагавар;

4.3.4.Шаардлагатай тохиолдолд бодлогын ирээдүйн төлөвт гарч болох өөрчлөлтийг тусгаж болно.

4.4.Мөнгөний болон Макро зохистой бодлогын шийдвэр, түүний үндэслэлийг хэвлэлийн хурлаар дамжуулан хуралдаан даргалагч танилцуулна.

4.5.Мөнгөний бодлогын мэдэгдлийг Монголбанкны цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлнэ.

4.6.Бодлогын мэдэгдлийг олон нийтэд түгээснээс хойш 1 ажлын өдөрт багтаан Мөнгөний болон Макро зохистой бодлого хариуцсан нэгж орчуулж, цахим хуудсанд байршуулна.

4.7.Хэвлэлийн хурлыг урьдчилж товлосон хуваарийн дагуу зохион байгуулах ажлыг Олон нийт, хэвлэл мэдээлэл хариуцсан нэгж гүйцэтгэнэ.

4.8.Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл явцын ил тод болон хариуцлагатай байдлыг хангах үүднээс шийдвэр гаргахад ашигласан эдийн засгийн өнөөгийн болон цаашдын төлөв, бодлогын хувилбар, хорооны гишүүдийн шийдвэр гаргахад өгсөн байр суурийг нэгтгэсэн мэдээллийг агуулсан “Мөнгөний бодлогын тайлан”-г Мөнгөний бодлого хариуцсан газар боловсруулж, Хорооны хуралдаанд танилцуулсаны дараа тогтсон хуваарийн дагуу улирал тутам олон нийтэд танилцуулна.

4.9.Мөнгөний зохистой бодлогын шийдвэр гаргах үйл явцын ил тод болон хариуцлагатай байдлыг хангах үүднээс шийдвэр гаргахад ашигласан эдийн засгийн болон банк, санхүүгийн салбарын өнөөгийн болон цаашдын төлөвийн талаарх мэдээллийг агуулсан “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г Макро зохистой бодлого хариуцсан нэгж боловсруулж, тогтсон хуваарийн дагуу жилд 2 удаа олон нийтэд танилцуулна.

4.10.“Мөнгөний болон Макро зохистой бодлогын шийдвэрийг олон нийтэд мэдээлсэнээс хойш хуанлийн 14 хоногийн дараа хуралдааны хураангуй тэмдэглэлийг Мөнгөний болон Макро зохистой бодлого хариуцсан газар, нэгжээс бэлтгэн Монголбанкны цахим хуудаст байршуулна.

4.11.Хураалдааны хураангуй тэмдэглэл нь тогтсон стандарт бүтэцтэй байх бөгөөд дараах мэдээллийг багтаасан байна. Үүнд:

4.11.1.Хуралдаанаар хэлэлцсэн асуудлын жагсаалт;

4.11.2.Бодлогын саналын танилцууллагын талаарх тойм;

4.11.3.Бодлогын саналыг дэмжсэн болон дэмжээгүй гишүүдийн үндэслэлийн талаарх тойм;

4.11.4.Хуралдаанаас гаргасан олонхийн шийдвэр болон саналын хувь.

4.12.Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, хэлэлцсэн асуудлын жагсаалтыг улирлаар товъёоглон дуут бичлэгийн хамт нууцын асуудал эрхэлсэн ажилтанд дараа улирлын эхний сарын 30-ны өдрийн дотор шилжүүлнэ.

4.13.Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг Тамгын газрын гүйцэтгэл хариуцсан ажилтан /цаашид тэмдэглэл хөтлөгч гэх/ хөтлөх бөгөөд хэлэлцсэн асуудлаар гишүүдийн хэлсэн үг, тавьсан саналыг үнэн зөв, бүрэн гүйцэд бичиж тэмдэглэнэ. Байгууллагын нууцыг хадгалах, хамгаалах талаарх холбогдох эрх зүйн зохицуулалтыг зөрчихгүйгээр хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг хиймэл оюун ухаанд суурилсан тэмдэглэл хөтлөгчөөр хийж болно. Хуралдааны тэмдэглэлийг хуралдаан хуралдсанаас хойш 3-н сарын дотор бичиж, МБХ-ны нарийн бичгийн даргад хүргүүлэх бөгөөд тэмдэглэлд тусгасан шийдвэрт дараа нь утга агуулгын өөрчлөлт оруулахыг хориглоно.

4.14.Хуралдааны тэмдэглэл хөтлөгч нь хөтөлсөн тэмдэглэлийнхээ нууцлалыг хадгалах үүрэг хүлээнэ.

ТАВ. БУСАД

5.1.Мөнгөний бодлогын хорооны хуралдаанд үр бүтээлтэй оролцох нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Хорооны гишүүн, нарийн бичгийн дарга, дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөгчид Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар нэмэгдэл олгоно.

5.2.Хорооны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Монголбанкны жил бүрийн төсөвт тусгаж, холбогдох журмын дагуу зарцуулна.

5.3.Хорооны гишүүн нь Төв банк (Монголбанк)-ны албан тушаалтанд хамаарах шаардлага, шалгуур, хязгаарлалт, ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгож дараах үүрэгтэй байна:

5.3.1.Хуралдааны товыг баримтлан, хуралдаанд оролцох;

5.3.2.Гишүүн нь бодлогын шийдвэр гаргах шатанд хэлэлцсэн бодлогын саналыг дэмжих эсхүл эсэргүүцэх чиглэлээр өөрийн байр сууриа холбогдох үндэслэлийн хамт бичгээр хорооны нарийн бичгийн даргад цахим шуудангаар шийдвэр гаргах хуралдаан болсоноос ажлын 1 хоногийн дотор хүргүүлнэ;

5.3.3.Хараат бус гишүүн мөнгөний болон макро зохистой бодлогын шийдвэр гаргахаас өмнө эдийн засгийн болон банк, санхүүгийн салбарын өнөөгийн болон ирээдүйн төлөвийн талаарх өөрийн байр суурь, мэдээллээ нууцлал бүхий цахим түүвэр судалгаагаар хуваалцаж, бодлогын шинжилгээ, төсөөлөлд өөрийн хувь нэмрээ оруулна;

5.3.4.Гишүүн нь Монголбанкны нэр хүнд, мөнгөний бодлогод олон нийтийн итгэх итгэлийг сахин хамгаалахад шаардагдах ёс зүйн өндөр хэм хэмжээг баримтлах;

5.3.5.Бусад гишүүдийн байр суурийг хүндэтгэн, хорооны хамтын шийдвэрт нэгдмэл байр суурьтай байх;

5.3.6.Хорооны гишүүн олон нийтэд чиглэсэн илтгэл тавих, яриа хийх, ярилцлагад оролцох, нийтлэл бичих, судалгааны ажил гүйцэтгэхдээ Хорооны шийдвэрийн талаар хувийн байр сууриа илэрхийлэхээс зайлсхийх бөгөөд хорооны хамтын шийдвэрийг олон нийтэд түгээгдсэн агуулгын хүрээнд хийх ;

5.3.7.Олон нийтэд мэдээлээгүй мэдээллийн нууцлалыг алдагдуулах, хорооны хэлэлцэх асуудал, хуралдааны явц, шийдвэрийн төслийг аливаа хэлбэрээр бусдад мэдээлэх, урвуулан ашиглахгүй байх;

5.3.8.Хорооны гишүүн олон нийтийг төөрөгдүүлсэн, санхүүгийн зах зээлд нөлөөлсөн ташаа мэдээллийг аливаа хэлбэрээр түгээхгүй байх;

5.3.9.Хуралдааны дэгийг сахиж, хуралдааны хэвийн үйл явцад саад учруулахгүй байх;

5.3.10.Бодлогын шийдвэрт санал өгөхдөө тооцоо судалгаатай, мэргэжлийн байдлаар хандах;

5.3.11.Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад мэдээллийн давуу тал олгохгүй байх.

5.4.Энэхүү журмыг зөрчсөн нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага хүлээх үндэслэл болно.

МОНГОЛБАНК